

# СОЁЛ СУДЛАЛ - ТҮҮХ

## ХҮРЭЭНИЙ САЙД САНДО-ГИЙН ШИНЭЭР ХИЙСЭН ХОЁР АЖЛЫН ТУХАЙ

*А. Ариунболд*

*Доктор /Ph. D/*

*Шинжлэх ухаан технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль*

*Хүмүүнлэгийн салбар  
bayan.boldoo@gmail.com*

*Хураангуй: Тус өгүүлэлд Чин улсаас 1901 оноос хэрэгжүүлж эхэлсэн “Шинэ засгийн бодлого”-ын хэрэгжих болсон шалтгаан, түүхэн үйл явцыг авч үзсэн бөгөөд тэр дундаа Халх монголд шинэ засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэн ажилласан хүний нэг болох Хүрээнд сууж хэрэг шийтгэгч, хамгийн сүүлчийн Манж амбан Сандогийн хийсэн хоёр ажлын тухай авч үзсэн болно.*

*Түлхүүр үгс: Чин улсын шинэ засгийн бодлого, Сандо амбан, хүрээ, зах зээлийн газар, хар тамхи*

### I. УДИРТГАЛ

*Хүрээний Манж сайдын газар ба Сандо амбаны тухай төвч өгүүлэх нь: Дэлхийн түүхийг бичилцэж явсан монголчууд ХҮШ зуун болоход хүч нөлөө нь буурч, нэгэнтээ шинээр мандан гарч ирсэн Манж чин улсын эрхшээл нөлөөнд орж эхлэсэн байна. 1636 онд Өвөр монгол, 1691 онд Халх монгол, 1758 онд Ойрад монголчууд залгаа залгаагаар Манж чин улсын харьяалалд орж эзлэгдсэн бөгөөд энэ л үеэс Чингийн төрөөс эзлэгдсэн газар орныг хамаарсан жанжин, сайдуудыг суулган захирах болжээ.*

*Чин улсын хаад Монгол газрын дээд эзэн болж, засаг ноёдод хошуу нутаг хувиарлан олгох төдийгүй үе улиран захиран суух эрх олгодог байжээ. Мөн Монгол хаад ноёдыг харьяат түшмэгээ хэмээн үзэж тэдэнд хэргэм зэрэг шагнах, угсаа залгамжлуулах, эс залгамжлуулах, албан тушаалаас нь огцруулах, нутгийн хил зааг тогтоож өгөх, цаазлан хороох, амыг нь хэлтрүүлэх зэрэг Монголын дээд эрх мэдлийг атган суух болов.*

*Хүрээний Манж сайдын газар: Хэдийгээр Улиастай хот Чин улсын төр мөхөх хүртэл Халх монголын төв хот болж байсан боловч Богдын Хүрээ аажмаар чухал нэгэн төв хот болсон байна. Халхын Өндөр гэгээний үеэс Хүрээ нь үргэлж нүүдэллэн нэг газраас нөгөө газарт шилжин суурьшдаг байв. Ингэж нүүсээр ХҮШ зууны хоёрдугаар хагасаас Богд хан уулын ар Хатан туулын хойд дэнж дээр дөрвөн уулын дундаа бүр мөсөн төвлөн суурьшснаар Хүрээний нэр Монголын түүхэнд тодоор бичигдэх болсон байдаг. Дараа нь шарын шашны сүм дуганууд баригдан түүнийг дагаад Хятад пүүс дэлгүүрүүд олноор бий болж,*

хүн амын тоо өссөн байна.

Манж нар эхэндээ Хүрээнд тусгай Манж сайдыг суулгаагүй бөгөөд харин Богдыг харгалзан тагнах Манж хиа болон бичээчийг суулгаж байв. Гэвч Хүрээний үүрэг нэмэгдэж, Оростой харилцах чухал нэгэн газар болсноор тусгай Манж сайд суулгах болжээ. Нөгөө талаар Улиастайн жанжны газар Халхын дөрвөн аймгийн хэргийг дангаар захиран шийтгэхэд хэрхэвч хүч хүрэлцэхгүй болсон учир Тэнгэрийг тэтгэгч (1736-1795) хааны 22 дугаар он буюу 1758 онд Хүрээнд сууж хэрэг шийтгэгч Монгол сайд нэг, туслах Манж сайд нэг хүнийг суулгаад, тус Хүрээний сайдын газарт Түшээт хан, Цэцэн хан, Их шавын зэрэг гурван газрын хэргийг хамааруулан өгчээ. Анх Хүрээний тэргүүн сайдад Монгол хүнийг тавьж байсан бөгөөд тэд цөм Манжийн хааны гүнжээс төрсөн, Монгол эцэгтэй хүмүүс байсан юм. Тухайлбал Хүрээний анхны Монгол сайд Сансрайдорж бол Манжийн хааны гүнжээс төрж, бага насандаа Манжийн хааны ордонд хүмүүжсэн хүн бөгөөд түүнийг нас барсны дараа түүний орыг залгасан хүү ван Юндэндорж бас л Манж гүнжээс төрсөн хүн байжээ. Сайд Юндэндорж бол хамгийн олон жил буюу 40 гаруй жил Хүрээний сайдын албан тушаалд суусан байдаг. Юндэндоржийг 1827 онд нас барахад Манжийн Төр гэрэлт (1821-1850) хаанаас “...Юндэндорж дөч илүү жил суугаад зарлигаар зарсан сайд лугаа дув дуугуй хэрэг шийтгээж зах хязгаарт өдий чинээн жил өчүүхэн ч сэв гаргасангүй. Үнэхээр итгээж хэрэглэхийг үтээрхэн гажсангүй”<sup>9</sup> хэмээн Чин вангийн хэргэмийг нь нэхэн өргөмжилж байжээ. Юндэндоржийн дараа Хүрээний сайдаар Дэлэгдорж хамааран ажиллаж байсан бөгөөд 1852 оноос Хүрээний тэргүүлэх сайдаар Манж хүнийг тохоон томилдог болов. Энэ үеэс Хүрээнд Манж сайд голлох үүрэгтэй болж харин Монгол сайд бэлэгдэлийн шинжтэй болсон байна.

Хүрээний сайдын газар нь 170 гаруй орон тоотой, нүсэр том газар болон хувирч, жилийн бүх зардалдаа арван мянга орчим лан мөнгийг зарцуулж байжээ.<sup>10</sup> Хүрээний сайдын газар алба хаах Монгол түшмэл, бичээч нар 4 сараар ээлжлэн Түшээт хан, Цэцэн хан аймгаас жасаалан суух журамтай байлаа. Хүрээний сайд нь Түшээт хан, Цэцэн хан аймаг, Богд Жавзандамба хутагтын шавийн хэргийг эрхлэхээс гадна Хүрээ Хиагтын жургааны зангийг хамааран захирч, бас Оростой харилцах явдлыг хянан байцаах үүрэг хүлээн ажиллаж байжээ.

Халх монголд Манж сайдуудыг Хүрээ, Улиастай, Ховд хотод суулгаж байсан ба тэд өөрсдийн хамаарсан газар орондоо Чингийн эрх захиргааг хэрэгжүүлж иржээ. Энэ дундаас түүхэн ээдрээтэй бас эгзэгтэй цаг үед, Хүрээг хамаарсан хамгийн сүүлчийн Манж сайдаар ажиллаж байсан Сандо (San Duo 三多 А.А) амбаны түүхэн үйл ажиллагаа нь түүхч, судлаачдын анхааралыг ихээр татаж ирсэн юм. Гэвч Сандо амбантай хамаа бүхий түүхэн материал

---

<sup>9</sup> Галдангийн эрдэнийн эрх. түүхийн тулгар бичиг. III боть, I-р дэвтэр. 1960 он. 157 тал. Иш татсан баүтээл- (Ш. Нацагдорж. Манжын эрхшээлд байсан үеийн халхын хураангуй түүх /1691-1911/. Улаанбаатар. 1963 он. 89 тал.)

<sup>10</sup> Бүгд найрамдах монгол ард улсын түүх. 3 боть. Дэд дэвтэр. Улаанбаатар. 1968 он, 187 тал.

хомсоос гадна, түүний тухай бичиж судалсан судалгааны бүтээл ховор байгааг дурдах хэрэгтэй болов уу. Иймээс миний бие зориг гарган чадан ядан Сандо амбантай хамаа бүхий Монгол улс дахь болон Хятад улс дахь дурдсан ном зохиол, судалгааны өгүүлэл болон Хүрээ сайдын айлтгал бичгүүд, Архивын сан хөмрөг дахь холбогдох материалуудыг цуглуулан ашиглаж, бичиж байгаа нь энэ билээ.

Сандо болвоос багаас Хятад газар өсч мөн Хятад боловсрол эзэмшсэн Монгол хүн юм. Тэр Чин улсын Жө –Жиан (Zhe Jian 浙江 А.А) мужийн Хан-Жоу (Hang Zhou 杭州 А.А) хотод төрсөн бөгөөд 1902 онд нийслэл Бээжин хотод шилжин ирж ажиллаж байгаад 1908 онд Гуй Хуа (Gui Hua 归化, Хөх хот А.А) -ын дэд захирагчаар томилогдон явж ажилласан байдаг. Дараа нь Халхын Хүрээг хамаарсан сайдаар томилогдон Хэвт ёстын (1909-1911) тэргүүн оны 12 сарын шинийн 1 нд Гуй Хуа (Gui Hua 归化 Хөх хот) -оос гарч энэ жилийн цагаан сарын 26 нд (1910 он А.А) Хүрээнд хүрч ирээд 2 сарын шинийн 1-ний өдөр өмнөх амбан Янь -Жи (Yan Zhi 延祉 А.А) -д түшмэл томилон амбаны тамга, бичиг, данс харааг хүлээн авч Хүрээний сайдын ажилдаа орж байжээ. Энэ тухай Сандо амбан өөрийнхөө айлтгалд дурдахдаа: “... Боол би Хэвт ёстын тэргүүн оны 12 сарын шинийн 1-нд Гуйхуа (Хөх хот А.А) -оос гарч энэ жилийн цагаан сарын 26 нд Хүрээнд хүрчээ” гээд цааш нь хэлэхдээ “... 2 сарын шинийн 1 ний өдөр урьд амбан Янь -Жи (Yan Zhi 延祉) -гаас түшмэл томилон амбаны тамга, бичиг, данс харааг хүргэж иржээ. Дариу ширээн дээрээ хүж асааж хааны зүг сөгдөн мөргөж, хүлээн аваад тушаалдаа оров” хэмээгээд “... өмнөх сайд Янь -Жи (Yan Zhi 延祉) - гийн Шинэ засгийн хүрээнд хийж байсан цэрэг, сургууль, худалдаа, уурхай, хар тамхыг цаазлах зэрэг урьд төрийн үеийн бэлтгэж хийсэн хэмжээт эрхэт засгийн ажилуудыг Хүрээний Монгол сайдтай хамжин, хамтаар гүйцэтгэе” Хэвт ёстын 2 дугаар оны 2 сарын шинийн нэгэн<sup>11</sup> хэмээн хаанд өргөсөн айлтгалдаа бичсэн нь дансанд үлдсэн байна. Сандо амбан Хүрээнд ирж сууснаас хойш шинэ засгийн бодлогын хүрээнд боловсрол, цэрэг, улс төр, хар тамхыг цаазлах, Хүрээний цагдаагийн газар байгуулах, уул уурхайгаас олох татварын асуудал, зам тээврийн харилцааг сайжруулах зэрэг ажлуудын бэлтгэл олон арга хэмжээ авч, шинэчлэлт өөрчлөлт хийж ажилласан баримтууд нилээдгүй байна. Түүхэн баримтыг сөхөн үзвэл Сандо Хүрээний сайдаар ажилласан богинохон хугацаандаа “Шинэ засгийн” олон ажлыг хийж гүйцэтгэсэн байх юм. Сандо амбан нь боловсрол өндөртөй, Чингийн төрөөс хүлээж авсан ажилаа хичээнгүйлэн гүйцэтгэдэг хүн байсан нь түүхэн баримтаас тодорхой харагдаж байна. Тэрээр Чин улсын хааны ордны ойр түшмэл төдийгүй танил тал олонтой хүн байсан байна. Мөн Сандо нь шүлэг яруу найргийг ихэд шимтэн сонирохдог байсан бөгөөд явсан суусан газар болгондоо шүлэг бичиж өөрийн тухайн үеийнхээ ажил амьдрал, бодол сэтгэлээ шүлэг яруу найрагтаа шингээн тусгаж бичдэг онцлогтой хүн байжээ.

---

<sup>11</sup> 《库伦奏议》，全国图书馆文献缩微复制中心，2004年，第（3-8）页。（《Хүрээний айлтгал бичгүүд》，Бүх улсын номын сангийн сурвалж бичгийг филм болгон хадгалах төв., Бээжин. 2004 он. 3-8 тал)

Хэдийгээр Сандо амбантай холбоо бүхий түүхэн данс хараа цөөн хэд байх боловч зарим нэгэн түүний бичсэн шүлэг, яруу найраг дотроос хувийн амьдралынх нь ховор чухал мэдээллүүдийг олж авах бололцоотой юм.

## II. ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

*Сандо амбан Хүрээний зах зээлийн газрыг цэгцэлсэн тухай:* Тухайн үед Хүрээ нь Халх монголын хамгийн том хот суурин газар байсан боловч, хот төлөвлөлт болоод соёлч аж байдлаар маруухан, хоцрогдмол бас нилээд бохир заваан хот байсан байна. Иймээс Сандо Хүрээг хамаарсан сайдаар очсны дараа Хүрээний дотоод дэг журмыг сахиулж, бас эмхлэж цэгцлэх ажлуудыг хийсэн байдаг. Сандогийн Хүрээний байдлыг илтгэсэн тухай айлтгалд: “...Жил бүрийн хаврын улиралд Хүрээнд Жавзандамба Хутагтад мандал өргөх ёслол хийдэг. Түүний ёслол үйлдэх зам дагуу худалдаа наймаа жигдэрч хөгжин, худалдаачид модон байшин барих буюу шууд газар дээр бараагаа дэлгэж худалдаа хийдэг. Энэ байдлыг харахад шоргоолж овооролдож байгаа мэт замбараагүй болой. Хүрээний лам нар зам нэвтэрэхэд саад болж байна гэсэн шалтгаанаар Бадаргуулт төрийн II (1886 он А.А) онд урьд Шанзудба ламтай хамт өргөн гуйчилсан ёсоор худалдааны гэр байшинг нураан зайлуулжээ. Энэ байдал нь олон улсын харилцаанд нөлөөлөх шахжээ (Тус газар Орос худалдаачид байсныг хэлж байна А.А) . Гээд Урьд амбан сайд Гүй шиан (Gui Xian 桂祥 А.А) зохихыг үзэж зарлиг буулган худалдааны нүүс хэдийг хаалгаж, хорио цээр тогтоон үүрд журамлуулахаар болжээ. Тэр үед хийсэн зүйл нь дансанд баймой<sup>12</sup>” хэмээн Хүрээний байдлыг дурджээ.

Энэ байдлыг илүү ойлгохын тулд Хүрээний өмнөх байдлыг дэлгэрүүлэн бичвэл Хүрээнд 1860 аад оны дундуур анх Хятад худалдаачид дараа нь Орос худалдааны дэлгүүрүүд бий болсноор Хүрээний зах үүссэн түүхтэй. Зах хэмээх үгийн утга нь бол Хүрээлэн буусан олон гэр байшингийн зах хаяа, уужим газар худалдаа хийдэг байснаас “Зах” хэмээх ил задгай худалдаа хийдэг газрын нэр томъёо бий болсон байдаг. 1870 аад он болоход Хүрээний зах нь тал бүрээсээ барилга хашаагаар хүрээлэгдсэн тусгай нэгэн худалдааны газар болжээ. Шөнийн цагт юуч үгүй хоосон болж, өглөө нар тусмагц тал бүрээс Монгол, Хятад, лам, хар худалдаачид, энгийн хүмүүс цугларан наймаа худалдаагаа хийгээд орой болж нар жаргамагц тарах бөгөөд “Зах өмнөөсөө умарш хүртэл 320 сажин, баруунаас зүүн хүртэл 60 сажин орчим талбай эзлэх”<sup>13</sup> бөгөөд захын худалдаачин Хятадууд 80-120 эсгий бүхээг засаж худалдаа хийдэг бол Монголчууд худалдах зүйлээ ихэнхдээ хайрцаг сав, эсвэл газар дэлгэн тавьж худалддаг байв. Монголчууд зах дээр ихэвчлэн тэмээ, морь, хонь худалдахын зэрэгцээ өвс, түлээ, гэр, гэрийн хогшил хэрэгслийг худалдаалдаг байлаа. Мөн чангаамал будаа, бор гурил, давс хужир, цагаан

<sup>12</sup> 《库伦奏议》，全国图书馆文献缩微复制中心，2004年，第（365）页。（《Хүрээний айлтгал бичгүүд》，Бүх улсын номын сангийн сурвалж бичгийг филм болгон хадгалах төв., Бээжин. 2004 он. 365 тал）

<sup>13</sup> Позднеев, Монголия и монголы. 107 тал.

идээний зүйлс, сур, дээс, тэмээний ноосон утас зэрэг монгол хүний өргөн хэрэглээний зүйлсийг ихээр худалдаалж байв. Бас хажууд нь жижиг махны зах болон төмрийн захууд байжээ.

1878 оноос Хүрээний зах дээр хоол цайны газрууд тусгай байртай болж, тэнд хүмүүс бэлэн хоол, цай, архи авч ууж идэх ба зарим хөдөөний хүмүүс ирвэл буудлах бөгөөд сүүлдээ Хүрээнд ирсэн жижиг түшмэд, худалдааны хүмүүс, лам нар ч бууж гардаг газар болсон байна. Улмаар Хятад пүүсийн бичээч, Монгол ноёдын хөвгүүд, лам нар учирсан бүсгүйчүүдтэй завхайрдаг гарзууд олон болсон ба бас архины дэлгүүр бий болсноор архи уух, хар тамхи татах хүмүүс цуглардаг газар болов. Хүрээний зах бол уйдсан лам нар хүмүүсийн цуглардаг газрын нэг байсан бөгөөд их бага хулгай, луйвар, зодоон цохионгүй өнгөрдөг өдөр нэг ч үгүй байжээ.<sup>14</sup> Үүний цэрэгцээгээр зах дээр өнчин, ядуу, сохор доголон, гуйлгачин, хуурчин хүмүүс олон байв.

Бас тэр үеийн Хүрээний байдлыг батлах нэгэн баримтыг Оросын аялагч, судлаач И.М.Майский бичиж үлдээхдээ: “... Хүрээ нь Хятад, Төвд маягийн хийц загвартай сүм дуганууд, цав цагаан өргөө гэр бүхий буддын шашны томоохон хийдүүд, шовх оройтой малгай өмсөж, гартаа эрх барин шар улаанаар тунаран алаглан харагдах мянга мянган лам хуврагууд, эрэн мяраан хувцас өмсөж энд тэнд хэсэг бүлгээрээ бөөгнөрсөн наймаачдаар дүүрсэн шороо тоос бүхий зах зээлийн талбай, шургааг мод шивээлэн босгосон зай завсаргүй хашаанууд (Дотроо гэр байшинтай) бүхий муруй саруй нарийхан гудамжнууд, өнгө өнгийн дээл өмсөж, бүсэндээ хэт хутга зүүсэн моритой Монголчууд, толгойгоо мөнгөн хэрэгсэлээр чимсэн эвэр мэт эхнэр үстэй Монгол эмэгтэйчүүд, тэн тэнгээр нь ачаа ачсан тэмээн хөсөгтөй, аажим сажлан яваа жингийн цуваа, урт хар хувцасаар биеэ ороосон мянга мянган хужаа, Хятадуудын мухлаг лангуунууд, Хятад, Монгол бичээс бүхий зурагт хуудас, нэр хаягууд, гудамжаар тэнүүчилсэн, яс мэрсэн, наранд биеэ ээн унтсан үй түмэн золбин нохой, хашаа хайсны ёроолд, гүүр доор, талбайн голд наранд ялзран хэвтэх хэдэн арван нохойн хүүр, хаа сайгүй овоорсон хог новш, нүдэнд тусаж байх ажээ. Тийм ээ тэр үеийн Хүрээ нэгдмэл нэг өнгө төрөхгүй байсан юм! <sup>15</sup>” гэж тэр номондоо дурдсан байх ажээ. Иймээс Сандо амбан Хүрээг эмх цэгцтэй болгон тохижуулах, хотын доторхи дүрэм журмыг тогтоох ажлыг эхлүүлсэн байна. Хүрээний баруун дамнуурчны гудманд байсан Хятад, Монгол голдуу жижиг худалдаачин, гуталчин, төмөрчин, оёдолчин, дархан, бас бус жижиг дэлгүүр ил худалдаа зэргийг шууд албадан зөөлгөж, хуучин амбасын яамны наад талын талбай дээр буюу Цэцэн ханы хорооны хойд талд <sup>16</sup> гудамжилан байрлуулж, зүүн баруун талд нь Орос маягийн өндөр хаалга босгож, түүгээр худалдаачин ба энгийн иргэдийг орж гаргах болгов”. Мөн тэр худалдааны газрын өмнө талд ший бүжиглэх өндөр тайз байшинг байгуулж,

---

<sup>14</sup> Л.Дүгэрсүрэн, Улаанбаатар хотын түүхээс. Улаанбаатар. 1956 он. 56 тал.

<sup>15</sup> И.М.Майский, Монгол орон хувьсгалын босгон дээр. (Орчуулсан Чойзонгийн Баатар) Улаанбаатар., 2015 он. 95 тал

<sup>16</sup> Л.Дүгэрсүрэн, Улаанбаатар хотын түүхээс. Улаанбаатар. 1956 он. 57 тал.

өдөр бүр Хятад ший бүжиг тоглуулж<sup>17</sup> Хүрээний ард олныг урлагаар соёлжуулж, зугаацуулах ажлыг хийжээ.

### Ш. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Энэ тухай Сандо амбаны айлтгалд: “...Эдүүгээ Урьд амбан сайд Гүй Шиан (Gui Xian 桂祥) -ны авсан арга хэмжээнээс хойш хорин жил өнгөрч, худалдаачид улам олон болжээ. Энэ жил шавийн яам олон удаа мэдүүлж, Монгол хүн, Хятад иргэн, Орос хүмүүс жижиж модон байшин барьсан нь шарын шашинд харш болой. Тэднийг газар заан нүүлгээрэй хэмээсэн. Яг үүнийг шалган хийж байтал учир мэдэхгүй лам нар элдэв цуурхал тарааж, эдгээр модон байшинг эрх биш галдах хэрэгтэй хэмээсэнд олноорой цочин хэлмэгджээ. Сайд би (Сандо А.А) нэг талаар цэрэг томилон хамгаалж нөгөө талаар тамгын газрын эс түшимэл болон Түшээт хан, Цэцэн хан, шавь гурван этгээдтэй хамтаар байцааваас аргыг олсон нь: Сайд (Сандо) миний яаман тамгын газрын зүүн, баруун, хойно, өмнө бүр албаны газар болмой. Тамгын газрын баруун талд хэдэн арван (Ү) -газрыг зах болгон нээж, тэдгээр жижиж худалдаачдыг II сарын шинийн 3-нд бүгдээр нүүн ирэхтүн хэмээн зарлигджээ ” гээд цааш нь “... Тус худалдааны газыг байгуулахад тамгын газраас 3000 лан мөнгөн зоосыг худалдаачдад зээлүүлэн, зах нээхэд дэмжлэг, худалдааны ажил өрнүүн болоход буцаан төлүүлэхээр болсон. Шинээр байгуулсан зах дэлгүүр одоо өөрийн өнгө төрхийг олсон бөгөөд Хятад Орос амар тайван, Монгол Хятад ажилдаа бахдан баярлаж ажиллаж байна” хэмээн айлтгажээ. Тэрээр Монгол хүний худалдаа хийх арга ажиллагааны талаар дурдахдаа: Монгол хүн мэдлэг нээгдээгүй, худалдаа хийх зан чанар огт үгүй, тиймээс хар тамхийг цаазалсан торгуулын мөнгөнөөс хэдэн зуун лан гаргаж шинэ маягийн зургаан том тасалгаатай байшин бариулж бараа дэлгэх газар болгоно. Ингэж Монгол, Хятад хүмүүсийг туршилага солилцуулна гээд тус зургаан тасалгаат худалдааны газрын урд мал амьтны зах байгуулж адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа худалдаалах газрыг хэсэглэн байгуулна хэмээн дурджээ.<sup>18</sup> Ийнхүү Сандо амбан шинэ засгийн бодлогоор дамжаад Хүрээний доторхи ил худалдаа зээлийг нэгтгэн цэгцэлж шинэ газар нүүлгэн авчирснаар хуучин эмх замбараагүй байсан Хүрээний худалдааны газар орчин үеийн боловсон өнгө төрхтэй болсон байдаг. Мөн дээр нь Хүрээний дээд лам нар болоод шашны авиваа үйл ажиллагаанд саад учруулахгүй болгосон юм. гэвч Сандо амбан Хүрээнээс хөөгдсний дараа Хүрээний захыг дахин өөр газарт шилжүүлэн нүүлгэсэн мэдээ байдаг.

*Сандо амбан хар тамхийг цаазласан тухай:* Чингийн төрөөс шинэ засгийн бодлогын хүрээнд авч хэрэгжүүлсэн нэгэн чухал асуудал бол хар тамхийг цаазлан хориглох асуудал байсан юм. Хар тамхины хэрэг явдлын өнгөрсөн

<sup>17</sup> Г. Навааннамжил, Өвгөн бичээчийн үгүүлэл, Улаанбаатар. 1956 он. 174 тал.

<sup>18</sup> 《库伦奏议》，全国图书馆文献缩微复制中心，2004年，第（362-363）页。（《Хүрээний айлтгал бичгүүд》, Бүх улсын номын сангийн сурвалж бичгийг филм болгон хадгалах төв., Бээжин. 2004 он. 362-363 тал)

түүхийг чухас дурдвал: Чин улсаас өрнө дахинтай явуулсан цэргийн мөргөлдөөн болох “Хар тамхины дайнаар (1839-1842)” Британичууд (Англи улс А.А) Чин улсын хаалгыг нээсэн хэрэг явдал болсон юм. Хар тамхийг Британичууд өөрийн колони (Эзэмшил газар А.А) болох Энэтхэгт тариалан үйлдвэрлэж Британийн худалдаачид Чин улсын нутаг руу нууцаар оруулан худалдаалж байв.

Хар тамхи нь Чин улсын эдийн засаг хийгээд хүн ардад ямар их хор хохирол учруулж байгааг сайн мэдэх учир 1800 оноос хойш хар тамхи тариалах, гаднаас оруулах, хэрэглэхийг хориглосон байв. Хар тамхид орсон тухайн үеийн Хятад хүмүүсийг дүрслэхдээ: “*Хоёр мөр нь сулбайн унжиж, нүдний нулимас нь цийлэгнээд, хамраас нь ус гоожиж, амьсгаа нь үе үе тасалдана. Тэд амьд авч үхсэнээс ялгаагүй*” хэмээн бичсэн байдаг. Хүмүүс хуйгаараа хар тамхинд орох юм бол удалгүй тэр үеийн төлбөрийн хэрэгсэл мөнгөний тухай ярихаа байя гэхэд улс оронд цэргийн алба хааж чадах хүнгүй, ажил хийх хүн ч олдохоо болино гэж ихээхэн түгшиж байжээ.

1839 оны 3 сард Чин улсын эзэн хаан Даогуан (Төр Гэрэлт 1821-1850 А.А) хар тамхитай тэмцэх ажил хариуцах Лин Зэ Шү (Lin Ze Xu 林则徐 А.А) гэдэг хүнийг эзэн хааны бүрэн эрхт төлөөлөгчөөр томилон зарлигдаж, гадаадын хөлөг онгоцууд зангуугаа хаян зогсож байсан Кантон (Гуаньдун мужын төв хот Гуаньжөү хотыг хэлж байна. Guang Dong 广东 мужын төв хот Guang Zhou 广州 А.А) руу илгээжээ. Лин Зэ Шү (Lin Ze Xu 林则徐) очоод хамаг ачаа бараагаа хураалгахыг шаардав. Гэтэл худалдаачид эсэргүүцэл үзүүлжээ. Иймээс худалдаачдын суух газрыг цэргээр бүслүүлж Чин улсын усан хилийн дотор байгаа бүх хар тамхийг хураалгасны дараа л тэднийг суллана хэмээн мэдэгдсэн байна. Ингээд эцэсдээ 20813 ширхэг хайрцаг буюу нэг сая гаруй килограмм хар тамхийг Лин Зэ Шүд (Lin Ze Xu 林则徐) гардуулснаар тэрээр бүслэлтээ зогсоов. Хураасан хар тамхийг нь хотын хаалганы дэргэд устгуулжээ. Эхэлж шатаагаад дараа нь далайд хаясан байна. Лин Зэ Шү (Lin Ze Xu 林则徐) хар тамхийг далайд хаяхийн өмнө лусын хаанд өглөг өргөх ёслол хийлгэж “Хорноос зайлахын тулд энэ газрыг орхин одохыг загас жараахайдаа хэлж хайрлана уу” хэмээн гуйн мөргөсөн байдаг.<sup>19</sup> Энэ үйл явдлаас болж дараагийн хоёр жилд нь Британийн хэдэн арван хөлөг онгоц, 20000 цэрэг, түүний дотор Энэтхэгийн 7000 цэргийн албан хаагч Чин улсын өмнөд болон зүүн эрэгт бууж Кантоныг эзэлж дараа нь Шанхай (Shang Hai 上海 А.А) хотыг цэрэг зэвсгийн хүчээр булаан авчээ. Чингийн арми зэвсэг муутай, байлдааны хөлөг онгоц байхгүй байсан учир ялагдсан байна. Ингээд 1842 оны Наньжингийн (Nan Jing 南京 А.А) гэрээнд гарын үсэг зурснаар Чин улс 21 сая мөнгөн долларын дайны төлбөр төлөхөөр болсон юм.

Хэрэг явдал ийнхүү дууссаны эцэст хар тамхины наймаа улам цэцэглэсэн байна. Энэтхэгийн Калкуттагаас Бомбей хот руу нийлүүлэх хар тамхины хэмжээ хоёр дахин нэмэгдэж, улмаар дараагийн арван жилийн эцэс

---

<sup>19</sup> Юн чан, Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Моононцагаан) Улаанбаатар. 2015 он, 32 тал.

гэхэд гурав дахин нэмэгдсэн байдаг. 1840 онд 15619 хайрцаг байснаа, 1841 онд 29631 болж, 1860 онд бүр 47681 мянган хайрцаг хүрсэн байна. Иймээс Чин улс буй болсон нөхцөл байдалд захирагдахаас өөр аргагүй болжээ. Хар тамхитай тэмцээд нэмэргүй гэдгийг ойлгоод 1860 оны 10 сард Чин улс дахь хар тамхины худалдааг чөлөөтэй болгожээ. Тэр үед гадаадаас орж ирэх хар тамхийг Хятад хүн (Хятад хүн гадаадын хар тамхи Yang Yao 洋药 А.А) гэж нэрлэдэг байжээ. Тухайн үед Чин улсад ажиллаж амьдарч байсан Америкийн шашин дэлгэрүүлэгч, эмч, хатагтай Хэллэнд “Намайг дуудлагаар Хятад айлд очих болгонд хар тамхитай гаанс өгнө, намайг татахаас татгалзахаар эхнэр хүүхдүүд нь их гайхдаг байлаа . Тэд гадаад хүн болгон хар тамхи татдаг гэж боддог байжээ”<sup>20</sup> хэмээн дурсан бичсэн нь бий.

Ийнхүү хар тамхийг хуульчилснаас хойш хагас зуун жил өнгөрчээ. Энэ үед албан ёсны тоо баримтаар Чин улсын хүн амын “бараг 30-40 хувь” нь хар тамхи татдаг болсон байв. Тухайд үед өрнөдийн хүмүүсийн хэвшмэл ойлголтоор Хятад хүн бол новширсон харанхуй оромжиндоо хар тамхи татан суудаг, заваан жигшмээр амьдаг байлаа. Иймд улс орныхоо байдалд санаа зовсон Манж, Хятад хүмүүс өрнийн шашин номлогчдын нэгэн адилаар хар тамхийг хэрэглэх явдлыг хориглохыг цуцалтгүй уриалж байв. Мөн дэлхийн олон нийт хар тамхины худалдааг хориглохыг дэмжиж байлаа. 1906 оны дундуур Британий Парламент хар тамхины асуудлыг авч хэлэлцсэн байдаг. Үүнтэй холбогдон Лондон хотод сууж байсан Чин улсын элчин сайд тэр дор нь төвдөө “Хэрэв бид хар тамхийг үнэхээр хориглох гэж байгаагаа ажил үйлээрээ харуулах юм бол Британчууд зөвшөөрч бидэнтэй хамтран ажиллана гэдэгт миний бие итгэлтэй байна” хэмээн мэдээлж байжээ.

Цыши хатан энэ далимыг ашиглан дараагийн арван жилийн хугацаанд Чин улсын нутагт хар тамхи үйлдвэрлэх, хэрэглэхийг үндсээр нь устгахаар төлөвлөж байгаагаа зарлан тунхаглажээ. Тэгээд улс орон даяараа жараас доош насны бүх хүнийг хар тамхи хэрэглэхийг хэрхэн болиулах талаар арван зүйл бүхий нарийвчилсан төлөвлөгөө гаргажээ. (Хөгшин настай хүмүүсийг бие мах бодийн хувьд хар тамхинаас гарч чадахгүй гэж үздэг байв) . Энэ үед Чин улсаас Британи улсад хандан хар тамхины худалдаагаа зогсоох хүсэлт тавьжээ. Британийн засгийн газар тэр дор нь хариуг нь өгөв. Британи улс Энэтхэгээс гаргах хар тамхины экспортоо жил бүр арав хуваасны нэгтэй тэнцэх хэмжээгээр бууруулахад бэлэн хэмээн хариу мэдэгдэв. Британи, Чин улсууд аль аль нь үүнийгээ “Ёс суртахууны томоохон алхам” гэж тэмдэглэж байсан боловч Британи улс их хэмжээний ашиг орлого алдаж байгаатайгаа шүд зуун эвлэрэв. Чин улс ийнхүү хар тамхитай тэмцэх ажил амжилтанд хүрч, Британи улсын хар тамхины худалдаа яваандаа ямарч үүрэггүй болсон байна<sup>21</sup>.

Энэхүү Чин улс даяар хар тамхийг цаазлан хориглох ажил Халх монголд ч нэгэн адил явагдсан юм. Учир нь Халх монголын Хүрээ, Улиастай,

---

<sup>20</sup> Юн чан, Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Моононцагаан ) Улаанбаатар. 2015 он, 34 тал.

<sup>21</sup> Юн чан, Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Моононцагаан ) Улаанбаатар. 2015 он, 506-507 тал.

Ховд зэрэг томоохон хот суурин газруудад Хятад худалдаачдыг дагаад хар тамхи татах явдал нилээд байсан байна. Ийм учраас 1908 онд Гадаад монголын төрийг засах явдлын яамнаас (Монгол журган<sup>22</sup>) Халхын Түшээт хан аймгийн чуулган даргад хар тамхи зэрэг хортой юм үл хэрэглэж болох учир зарлиг тушаасан бичгийг илгээж байсан баримт байна.

Тус бичигт: Гадаад монголын төрийг засах явдлын яамнаас хар тамхи зэрэг хортой юм хэрэглэж үл болох учир зарлиг тушаасан хэрэг.

Гадаад монголын төрийг засах явдлын яамны бичиг Түшээт хан аймгийн чуулган даргад тушаан илгээв.

*Тушаан явуулахын учир: Цаазын явдалын яамны илгээсэн бичигт хар тамхи худалдан авах ба хануурыг (Хар тамхи татахад хэрэглэдэг багаж А.А) үйлдэж хийх ба тамхи тарих зэрэгт хуулийн хамт нийлж хэлэлцэн айлтгасан нь: Хар тамхи хэрэглэвээс амь хохирох, үүнээс хойш хануурыг үйлдэж хийх ба тавьж ханасан хүнийг, бас хорыг хийж хадгалсан хүнийг цаазын хууль ёсоор цавчин алж басхүү харьяат бүхнийг даруу байцаан битүүмжилсүгэй. Хэмээн журганаас хүргэж эржүхүй. Үүнийг харьяат чуулган даргад тушаан явуулж улмаар харьяат захирах газарт ухуулж нэгэн адил журамлан дагасугай. Үүний тул тушаан илгээв Бадаргуулт төрийн гучин гуравдугаар он, намрын тэргүүн сарын арван гурван<sup>23</sup> Гэжээ. Энэ мэтээр Чингийн төрөөс хар тамхи татахыг хориголосон хатуу хууль дүрэм гарган мөрдүүлж байлаа. Гэвч Халх монголд зарим нэгэн худалдааны пүүс, дэлгүүрүүд хар тамхийг худалдаалсан хэвээрээ байв. Энэ нь хар тамхитай тэмцэх ажил төдийлөн үр дүнтэй байгаагүйг харуулж байгаа юм. Тухайлбал Хүрээнд суух Хятад иргэд болон Хятад худалдаачидтай гэр бүл болсон зарим нэгэн Монгол эмэгтэйчүүд хар тамхинд орж, татаж байсан мэдээ баримтууд байдаг билээ. Иймд Сандо Хүрээний сайдаар томилогдон ирсний дараа хар тамхийг цаазлан хориглох шинэ засгийн бодлогыг эрчимтэйгээр хэрэгжүүлж эхлэсэн юм. Бас нэгэн зүйлийг нэмж хэлэхэд Хүрээнд сууж байсан өмнөх Манж сайдууд хар тамхитай тодорхой хэмжээнд тэмцэж байсныг дурдах хэрэгтэй юм.*

#### IV. ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Сандо амбаны хэлснээр бол Монгол газар уур амьсгал хүйтэн болохоор хар

---

<sup>22</sup> “Гадаад монголын төрийг засах явдалын яам (ГМТЗЯЯ) ” Тус яамны нэрийг сурвалж бичигт “Монгол журган”, “Их журган” гэж нэрлэж бичсэн байдаг. Журган гэдгийг “Явдлын яам” мөн Хятадаар (li fan yuan 理藩院) гэдэг. Тус яам нь дотоод гадаад монголчуудын хэргийг нэгтгэн шийтгэх эрх бүхий шүүх, засаг захиргааны асуудлыг бүрэн хариуцсан Манж чингийн төрийн захиргааны байгуулга юм. Өөрөөр хэлбэл Журган нь аймгийн чуулган дарга, жанжин, эрдэнэ шанзудба нарт хэнийг томилох, засаг ноёдод хэргэм зэрэг шагнах ба залгамжлуулах, мөн тайж нарт зэрэг шагнах, ба залгамжлуулах тэдгээрт зэрэг олгох, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг “Зарлигаар тогтоосон гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”-ийн заасан хүрээнд хэрэгжүүлэх, зарим нэгэн асуудлыг хааны зарлигаар шийдвэрлэх эрх бүхий төрийн захиргааны эрх бүхий байгууллага байв.

<sup>23</sup> МУУТА., ФМ-9, Д-2, ХН – 2053, 1 тал.

тамхи тарьдаггүй. Тийм учир тарихыг цаазалсан хэргийг зөвлөлдөх хэрэггүй хэмээн дурдсан байдаг. Үүнээс үзвэл Халх монголд хар тамхийг тарьдаггүй, харин дотор газраас авч ирсэн худалдааны хар тамхийг хэргэлэдэг байсан нь тодорхой байна. Дээрх баримтыг баталхын тулд Хүрээний сайд Сандогийн хаанд өргөсөн айлтгалд дурдсан нь: Зарлиг ёсоор хар тамхийг цаазалсан байдлыг мэдүүлсэн тухай айлтгалд: “...Монгол газар хүйтэн болохоор хар тамхийг ер тариалдаггүй. Тэгэхээр хар тамхийг цаазлахад 1-р тарихыг цаазална, 2-р татахыг цаазална, 3-р худалдаалахыг цаазална” гээд “...Гадаад Монголчуудын амьдрах арга нь бүдүүлэг учраас хар тамхийг татах хүн дэмий үгүй. Гагцүү Хүрээний газар нь Монгол, Хятад, гадаад дотоодын худалдааны зах болохоор хүн ам олонтой. Тамхи татах газар болон хар тамхи татдаг хүн бол байдаг. Дэн буудал болон худалдаачдын дунд хар тамхинд донтсон хүн зөндөө буй” гэжээ. Хүрээн дэх энэ байдлыг засаж залруулахын тулд Сандо амбаны нэн тэргүүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ бол хар тамхи цаазлах товчоог эрүүл хамгаалалын товчоонд нэгтгэн оруулаад Хятад, Орос эмчийг ажиллуулан хар тамхинд орсон хүмүүст эм уулгаад эмчлэгдсэн хүний тоо нилээд байгаа тухай Сандо амбан дурдсан байна.

Мөн цааш нь Хүрээнд хар тамхийг цаазлан хориглосон арга хэмжээнүүдийг дурдвал: Хэвт ёстын 2 дугаар оны 9 сарын 19 нд хаан зарлиг буулгасан байна. “...Эл мужийн жанжин, бүгдийг захирах сайд нарыг хянамгай байцаан шаардаж, үнэн бодитой цэгцэлэн, хүчийг жаахан ч гэсэн сулруулж болохгүй. Гэсэн хааны зарлигыг үндэслэж Сандо амбан дахин арга хэмжээ авсан байна. Үүнд 1. Хар тамхи худалддаг нүүсэд тусгай гэрчилгээ олгох. 2. Хар тамхи худалдан авч татдаг иргэдэд (Хятад хүнийг хэлж байна А.А) тусгай гэрчилгээ олгох.

- Энэхүү гэрчилгээ бичиг нь 1 сарын хүчинтэй бөгөөд дуусвал сар болгон дахин авна. Тус зөвшөөрлийн гэрчилгээг эрүүл хамгаалалын товчооноос олгодог байжээ.
- Нэг лан<sup>24</sup> (Хэмжих нэгж А.А) боловсруулсан (Чанасан А.А) хар тамхинд олгох гэрчилгээний сүйтгэл нь 1 цэн 5 пун мөнгөн зоосоор авна.
- Нэг лан түүхий (боловсруулаагүй А.А) хар тамхинд олгох гэрчилгээний сүйтгэл нь 1 цэн мөнгөн зоосоор авна.
- Иргэн хүн (Хятад хүнийг хэлж байна А.А) 1 өдөрт нэг пэн хар тамхи татвал 1 сард 2 пун мөнгөн зоосны сүйтгэл тушаана
- Тэр хар тамхи татаж буй хүнд сар болгон олгох хар тамхийг 10 хуваасны 1 хувиар багасгаж хэрэглүүлсээр аажмаар үгүй болгоно. гээд
- Дээрхи 10 хуваасны 1 хувиар багасгах хязгаарлалт нь өндөр настай болон өвчтөй хүнд үйлчлэхгүй гэж заажээ.
- Мөн Түшээт хан, Цэцэн хан аймгийн газар нутаг уужим, хүн ам нь цөөн болохоор чуулган даргад тушааж, үнэн бодитой байцаан цаазалж, хар тамхи татах хүнийг байцаан гаргаж гэрчилгээ бичиг олгуулна” гэж, Сандо

<sup>24</sup> “Лан” Монголд хэрэглэж байсан хуучны хүндийн хэмжүүрийн нэр. 1 лан нь 37,3 грамм буюу 10 цэнтэй тэнцэнэ. 1 цэн нь 10 пун болно. 10 пун нь 10 ху болно. 1 ху нь 10 си-тэй тэнцэнэ.

амбан эрүүл хамгаалалын товчоонд зарлигдсан байна.

Цааш нь “...Сайд би (Сандо А.А) цэргийн зүүн хороо хийгээд баруун хүрээнд (Гандан<sup>25</sup> А.А) өмнө байсан тамхины газруудыг зарлигдан хаалагаж, тамхи татахад хэрэглэх багаж зэвсгийг хураан авч галдан шатаажээ. Бас тамхи татах газар ажиллуулдаг зарим нэг хөрөнгө мөнгөөр буурай хүмүүст нөхөн олговор олгосон байна. Зарим нэг зарлиг дагахгүй тамхины газрын эздийг баривчлан авч, тамхи цаазлах дүрмийн 3 дугаар зүйл ёсоор шийтгэнэ. Мөн худалдаачид дундах нэр хүнд бүхий хүмүүсээр хамжилцан ажиллуулна” Гээд Хүрээн дэх хар тамхийг цаазлах хориглох ажилд зарцуулагдах зардал мөнгийг гэрчилгээ олгоход орж ирсэн болон торгуулиас ирэх мөнгөнөөс олж зарцуулна гэжээ.

Бас Сандо амбан Гаалийн ерөнхий товчоонд зарлиг хүргүүлэн “...Хилээр орох барааг чанга байцаан шалгаж, хэрвээ хар тамхи байваас хэн зөөвөрлөж байгаа, өөрөө татах гэж байгаа юу, эсвэл худалдаалах гэж байна уу гэдгийг нарийн байцааж, эрүүл хамгаалалын товчоонд мэдүүлэн дансанд тэмдэглүүлнэ. Харин нуун далдалбал нарийн байцааж чанга торго<sup>26</sup>” хэмээн зарлиг хүргүүлсэн байна. Ингээд Сандо амбан үзэхдээ бид энэ мэтээр ажиллавал нэг жилийн дараа хар тамхийг цэвэрлэн, тасалж дийлнэ хэмээн Хүрээний тамхи цаазлах ерөнхий төлөвийг илтгэсэн байдаг. Халх монгол дахь хар тамхины хэрэглээний нэг онцлог нь бүх хар тамхи татдаг хүмүүс зөвхөн Хүрээнд ирж татах хар тамхиа худалдаж авдаг байсан байгаа юм. Иймд Сандо хар тамхийг цаазалахад нилээд дөхөм байсан бололтой.

## V. ДҮГНЭЛТ

Чин улсын төр тухайн үеийн дэлхий дахины хувьралт өөрчлөлт болоод хүчирхэг улсуудын колончлох бодлогын нөлөөллөөс болж улсаа засах уламжлалт бодлогоо өөрчлөн “Шинэ засгийн бодлого” гэгчийг зарлан явагдуулжээ. Тус шинэ засгийн бодлогоор улс төр, эдийн засаг, цэрэг зэвсэг, соёлын салбарт шинэчлэлт хийгдэхээр төлөвлөгдсөн байна.

Улмаар Монгол нутагт Хятад иргэдийг олноор суурьшуулж, тариа тариулан, байгалийн баялагийг ашиглах, банк, сургууль, хэвлэл, урлаг соёлын

---

<sup>25</sup> “Гандантэгчилэн” Их хүрээний баруун хэсгийг Гандан буюу Гандан тэгчилэн гэж нэрлэнэ. Тэнд Дашчоймпэл, Гунгаачойлон, Ядгаачойлон, хэмээх цанидын гурван үндсэн дацан байснаас гадна 1838 онд байгуулагдсан Гандантэгчилэнгийн ордон сүм бас 1913 онд барьсан 30 тохой Мигжиджанрайсгийн сүм зэрэг шүтээний сүм дацангууд оршиж байв. Энд шашны сургалт явуулахын зэрэгцээгээр зурхай, ламрин, эмнэлэг зэрэг салбар дацангууд ажиллаж хурал номын үйлийг хөтлөн гүйцэтгэдэг байжээ. Иймээс Гандан бол Их хүрээн дэх шашны эрдэм боловсролын нэгэн томоохон төв болон ажиллахын зэрэгцээ шашны дээд номыг судлахад зориулагдсан гүн ухааны төв болж байв.

<sup>26</sup> 《库伦奏议》，全国图书馆文献缩微复制中心，2004年，第（345-358）页。（《Хүрээний айлтгал бичгүүд》，Бүх улсын номын сангийн сурвалж бичгийг филм болгон хадгалах төв., Бээжин. 2004 он. 345-358 тал）

газруудыг шинээр байгуулан томоохон хот суурингуудыг шинэчлэн тохижуулаад бага ч гэсэн шинэ цагийн боловсон өнгө төрхтэй болгов.

Ялангуяа Халх монгол оронд Сандо амбан Чингийн шинэ засгийн бодлогыг богино хугацаанд идэвхитэй хэрэгжүүлсэн бөгөөд Хүрээнд олон шинэ өөрчлөлтүүдийг хийсэн байна. Тухайлбал бидний дээр авч үзсэн Хүрээний олон нийт цуглардаг зах зээлийн газрыг шинэчлэн тохижуулсан явдал нь хэдэн зуун жилээр хувьралтгүй тогтож, хоцрогдсон хэв загварыг эвдэж, шинэ цагийн өнгө төрхийг бий болгосон явдал байжээ. Бас хар тамхинд живээд байсан Чин улс нь шинэ төрийн бодлогоор хар тамхинаас ард иргэдээ хамгаалсан дэс дараатай арга хэмжээ авч байснаар хуучин тогтсон замбараагүй байдал хумигдаж эхэлжээ.

Тайлбар:

“Гадаад монголын төрийг засах явдалын яам (ГМТЗЯЯ)” Тус яамны нэрийг сурвалж бичигт “Монгол журган”, “Их журган” гэж нэрлэж бичсэн байдаг. Журган гэдгийг Монголоор “Явдлын яам” харин Хятадаар (li fan yuan 理藩院) гэдэг. Тус яам нь дотоод гадаад монголчуудын хэргийг нэгтгэн шийтгэх эрх бүхий шүүх, засаг захиргааны асуудлыг бүрэн хариуцсан Манж чингийн төрийн захиргааны байгуулга юм. Өөрөөр хэлбэл Журган нь аймгийн чуулган дарга, жанжин, эрдэнэ шанзудба нарт хэнийг томилох, засаг ноёдод хэргэм зэрэг шагнах ба залгамжлуулах, мөн тайж нарт зэрэг шагнах, ба залгамжлуулах тэдгээрт зэрэг олгох, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг “Зарлигаар тогтоосон гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”-ийн заасан хүрээнд хэрэгжүүлэх, зарим нэгэн асуудлыг хааны зарлигаар шийдвэрлэх эрх бүхий төрийн захиргааны байгууллага байв.

“Лан” Монголд хэрэглэж байсан хуучны хүндийн хэмжүүрийн нэр. 1 лан нь 37,3 грамм буюу 10 цэнтэй тэнцэнэ. 1 цэн нь 10 пун болно. 10 пун нь 10 ху болно. 1 ху нь 10 си-тэй тэнцэнэ.

“Гандантэгчилэн” Их хүрээний баруун хэсгийг Гандан буюу Гандан тэгчилэн гэж нэрлэнэ. Тэнд Дашчоймпэл, Гунгаачойлон, Ядгаачойлон, хэмээх цанидын гурван үндсэн дацан байснаас гадна 1838 онд байгуулагдсан Гандантэгчилэнгийн ордон сүм бас 1913 онд барьсан 30 тохой Мигжиджанрайсгийн сүм зэрэг шүтээний сүм дацангууд оршиж байв. Энд шашны сургалт явуулахын зэрэгцээгээр зурхай, ламрин, эмнэлэг зэрэг салбар дацангууд ажиллаж хурал номын үйлийг хөтлөн гүйцэтгэдэг байжээ. Иймээс Гандан бол Их хүрээн дэх шашны эрдэм боловсролын нэгэн томоохон төв болон ажиллахын зэрэгцээ шашны дээд номыг судлахад зориулагдсан гүн ухааны төв болж байв.

## НОМ ЗҮЙ

1. МУУТА., ФМ-9, Д-2, ХН – 2053
2. 《库伦奏议》，全国图书馆文献缩微复制中心，2004年，第（）页。（《Хүрээний айлтгал бичгүүд》，Бүх улсын номын сангийн сурвалж бичгийг филм болгон хадгалах төв., Бээжин. 2004 он.)
3. Галдангийн эрдэнийн эрх. түүхийн тулгар бичиг. III боть, I-р дэвтэр. 1960 он.
4. Г. Навааннамжил, Өвгөн бичээчийн үгүүлэл, Улаанбаатар 1956 он.
5. Л.Дүгэрсүрэн, Улаанбаатар хотын түүхээс. Улаанбаатар 1956 он.
6. Галдангийн эрдэнийн эрх. түүхийн тулгар бичиг. III боть, I-р дэвтэр. 1960 он.
7. Ш.Нацагдорж. Манжийн эрхшээлд байсан үеийн халхын хураангуй түүх /1691-1911/. Улаанбаатар 1963 он.
8. Бүгд найрамдах монгол ард улсын түүх. 3 боть. Дэд дэвтэр. Улаанбаатар 1968 он.
9. Позднеев, Монголия и монголы.
10. И.М.Майский, Монгол орон хувьсгалын босгон дээр. (Орчуулсан Чойзонгийн Баатар) Улаанбаатар 2015 он.
11. Юн чан, Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан: Д.Моононцагаан) Улаанбаатар 2015 он.
12. Б.Төмөрбагана, Дайчин гүрний хүрээнд суусан хамаг сүүлчийн их сайд сандо хийгээд түүний

дээш айлтгасан бодрол бичгүүд, Өвөр монголын Багшын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл. \2009 оны 4 дүгээр хугацаа\.

13. 李桔松: 从《可园诗抄》看三多任库伦办事大臣前后之心路历程,《中国边疆史地研究》, 2016年6月第26卷第2期.